



## ОЮУ ТОЛГОЙН ХЯНАЛТ ТББ

Оюу Толгой Хяналт ТББ нь олборлох салбарын хүний эрх ба байгаль орчны зарчим ба стандартын нийцлийн хяналт мониторинг, эрхийг хамгаалах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зорилго бүхий нийгэмд үйлчилдэг ашгийн бус байгууллага болно.

Үйл ажиллагаа эхэлсэн – 2009\10 сар

Бүртгэгдсэн – 2010\3 сар

ЭРХЭМ ЗОРИЛГО - ХҮНИЙ ЭРХ, АМЬДРАХ ОРЧНЫГ ХАМГААЛАХ

ЗОРИЛГО: Оюу Толгойн Хөрөнгө оруулалт (ХО)-ын гэрээний хэрэгжилтийг хүний эрх, байгаль хамгаалах стандартад нийцүүлэх явцад хяналт тавих

ЗОРИЛТУУД:

- ✚ ХО-ын гэрээ Үндсэн хууль, олон улсын хуульд нийцсэн эсэхийг тогтооход хувь нэмэр оруулах
- ✚ ХО-ын гэрээний хэрэгжилтийг хуулинд нийцүүлэх эрх зүйн орчин хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах
- ✚ Стратегийн орд газрыг ашиглах үйл ажиллагаанд нийцлийн мониторинг хийх механизм ба чадавх хөгжүүлэх
- ✚ Орон нутгийн иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжих
- ✚ Олборлох компаниуд Компанийн нийгмийн хариуцлага КНХ-ын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нийцлийн хяналт тавих чадавх хөгжүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛҮҮД:

- Оюу Толгойн ХО-ын гэрээг МУ-ын хууль, ОУ-ын хуулийн зарчмуудад нийцсэн эсэхийг судлах, баримтжуулах
- Оюу Толгойн ХО-ын гэрээний хэрэгжилтэд нийцлийн хяналт тавих, эрхийг хамгаалах
- Судалгаа, нийцлийн хяналтын үр дүнд үндэслэн олон нийтийн нөлөөллийн ажил, сургалт хийх
- Хүний эрх, байгаль хамгааллын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Орон нутгийн иргэний нийгэмтэй харилцаа хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах
- Олон улсын иргэний нийгмийн сүлжээнүүдтэй харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх
- Хөрөнгө босгох төсөл боловсруулах, хэрэгжүүлэх

## 2011 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

➤ Оюу Толгойн ХО-ын гэрээг МУ-ын хууль, ОУ-ын хуулийн зарчмуудад нийцсэн эсэхийг судлах, баримтжуулах

Оюу Толгойн төсөлд ХОГ-ний хувьд нэмэлт судалгаа хийгдээгүй боловч гэрээг өөрчлөх, шударга болгох, тотворжуулалтын хугацааг олон улсын жишигт нийцүүлэх зэрэг асуудлуудаар хэвлэлд мэдээлэл өгөх зэргээр нөлөөллийн ажил хийгдэж ирсэн болно.

➤ Оюу Толгойн ХО-ын гэрээний хэрэгжилтэд нийцлийн хяналт тавих, эрхийг хамгаалах үйл ажиллагааныхаа чиглэлийн хүрээнд Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд мониторинг хийх, Рио Тинто\Оюу Толгой ХХК-тай холбоо тогтоож, улирал тутмын уулзалт, албан бичгээр мэдээлэл солилцох зэргээр дараах асуудлууд дээр ажиллаж ирсэн:

Оюу Толгойн төслийн нөлөөллийн бүсэд мониторинг\тандалтын ажил:

1. 2011 оны 4 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд Оюу Толгойн төслийн нөлөөллийн бүсэд мониторинг
2. 2011 оны 6 дугаар сарын 6-11-ний өдрүүдэд ТЗЕ Банквотч (Central and Eastern Europe Bankwatch Network) сүлжээтэй хамтрасан Ханбогд-Цогтцэций сумдууд дахь хүний эрх ба байгаль орчны нөлөөллийн судалгаа
3. 2011 оны 8 дугаар сарын 3-7-ны өдрүүдэд сургалтын бэлтгэл ажлаар Дорноговь аймгийн Хатанбулаг, Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций, Манлай сумдад уулзалтууд, мэдээлэл цуглуулалт
4. 2011 оны 9 дүгээр сарын 19-нөөс 10 дугаар сарын 5-н хүртэл “Олон улсын стандартын нийцэл-Уугуул иргэдийн хяналт” сургалтыг Дорноговь аймгийн Хатанбулаг, Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций, Манлай сумдад хэрэгжүүлэх явцад Канадын Их сургуулийн докторант Сара Жексонтой хамтарсан мэдээлэл цуглуулах судалгаа
5. 2011 оны 11 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд Нийцлийн Хяналтын Нэгж \НХН\-ийн сургалтын явцад мэдээлэл цуглуулалт, бэлгийн дарамтын асуудлаар мэдээлэл авах зэрэг мониторингийн ажил хийгдсэн.

Мониторингоор илрүүлсэн асуудлуудыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх, олон нийтэд мэдээлэх, нөлөөллийн зорилгоор дараах асуудлуудыг гаргаж тавьсан болно. Үүнд:


2010 оноос хойш зарим асуудлууд дээр арга хэмжээ авах, жишээлбэл ОТ-н кэмпээс Хятадын хил рүү тавих замын эцсийн чиглэлийг ЗТБХБЯ-наас баталтал, иргэдийн оролцоо бүхий хэлэлцүүлэг хийтэл замын ажлыг түр зогсоох, эдийн засгийн суурьшил алдсан иргэдэд олгох нөхөн олговорын гэрээг өмнөх шилжүүлэн суурьшуулах гэрээнээс сайжруулсан байх зэргээр ахиц гарсан боловч Айвенхоу Майнз\ Рио Тинто буюу Оюу Толгой ХХК, түүний бэлтгэн нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд зарчмын өөрчлөлт гараагүй тул иргэдийн бухимдал улам нэмэгдсэн байна. Энэ жилийн мониторингийн ажлыг 2011 оны 4 сарын 23-27 өдрүүдэд бие даасан мониторингоор эхлүүлж, нийт 5 удаа сургалт, гадаадын байгууллагаа, судлаачидтай хамтрах, нэгтгэх зэргээр гүйцэтгэж дараах асуудлуудыг компани, Монгол улсын холбогдох яамд, түүний дотор ерөнхийлөгч, ерөнхий сайд нарт танилцуулан арга хэмжээ авах санал дэвшүүлсэн болно.

Үүнд:

**I. Газрын зөвшөөрөл, ТЭЗҮ, ХОГ-нд тусгагдаагүй асуудлууд**

- Гүний Хоолой дахь усны нөөц газраас ус татах 75 км усны хоолой тавих, зам ба олон улсын нисэх онгоцны буудал барих зэрэг ажлыг эхлүүлсэн хойно иргэдээр хэлэлцүүлэх, газрын зөвшөөрөл авах зэргээр хуулийг зөрчих, иргэдэд тулган зөвшөөрүүлэхийг шаардах хэлбэрээр ажилласаар байна. Шинээр хэд хэдэн ажилчдын кэмп, тэдгээр рүү хүрэх зам, дулааны станц, нисэх онгоцны буудал, уурхайн хаягдлын далан зэрэг асар том хэмжээний барилгын ажил явагдаж байгаа бөгөөд тухай бүрт газрын зөвшөөрөл авах, түүний өмнө байгаль орчин, нийгэм-эдийн засаг, түүний дотор эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй байсаар байна.
- Эдгээр барилгын ажлын явцад Ундайн голыг Бумбатын адагт (43°02'58.1"-E106°48'32.4"), дулааны станц г.м. том барилга руу явсан зам (N430 01" 45.3"-E106°49'05.6") 3-4 газар тасалсан байна. Бидний баг хүрч очих боложгүй хаагдсан газар GPS-ийн мэдээлэл авч чадаагүй болно. Эдгээр барилгын ажлуудын ихэнх нь ТЭЗҮ, ХОГ-нд тусгагдсан боловч голын урсгалыг таслах, хаах асуудлууд нь БОНБУ-нд тусгагдаагүй, иргэдээр хэлэлцүүлэгдээгүй болно. Эдгээр нь өнгөрсөн хугацаанд голын урсгал тасалсан газрууд дээр шинээр нэмэгдэж буй тасалсан газрууд байна.

Оюу Толгойн сателит зураг 2011.04.14 байдлаар



- Шинээр байгуулагдсан Өмнөд Кэмп гэдэгт газрын зөвшөөрөл, БОНБУ, байгаль хамгаалах төлөвлөгөө зэрэг нь байсангүй. Айвенхоу Майнз, Рио Тинто, Оюу Толгой ХХК-ийн гэрээт гүйцэтгэгчид ажиллуулж буй кэмпиин газрын зөвшөөрөл, БОНБУ, байгаль хамгаалах төлөвлөгөө нь хаана байдаг, хэн хэрэгжүүлэх ёстойг мэдэхгүй Монгол гүйцэтгэгч компани байна. Хятад ажилчдын кемпийн хувьд монгол хэл мэдэх хүн байхгүй тул юм асуухад хариулах хүнгүй, орох боломжгүй улмаар хяналт тавих боломжгүй кэмпүүд байгуулагдсан байна.
- Компани нь мөн ХО-ын Гэрээнд тусгагдаагүй хүнд даацын ачааны онгоц буулгах буудал байгуулах газрын зөвшөөрөл хүссэн байна. Одоогийн байдлаар орон нутгийн захиргаа зөвшөөрөөгүй байгаа боловч нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагын эрх мэдлийг булаан хүчээр зөвшөөрлүүд гаргуулж байга ЗГ-ын бүрэн эрхэт төлөөлөгчийн тухай асуудал байна.
- Хайрга, элс зэрэг барилгын материал олборлохдоо хамгийн ойр дөт байгааг нь байгаль орчны нөлөөллийг үл харгалзан Ундайн голын сайр, хайлас ургаж байгаа

газраас татаж байна. Хайлаас ургаж байгаа газраас өгөхгүй гэж нутгийн иргэд эсэргүүцэхэд модыг нь шилжүүлэн суулгаад элс сайрыг нь авч байна. Ингэхдээ “техникийн хувьд хамгийн тохиромжтой” гэсэн үндэслэл гаргадаг бөгөөд түүнийг нь орон нутагт шалгаж хянах чадавх байдаггүй байна.

- Компани нь байгуулсан кемп, барилгын материал татах карьер тухай бүрт хүрэх замыг хусах, тэгшлэх зэргээр тодорхой хэмжээний замын ажил хийсэн байгаа нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөлж байгаа бөгөөд БОНБҮ хийлгээгүй байна.
- ЗГ-ын бие төлөөлөгч НӨУЁБ-ын бүрэн эрхэд халдаж Оюу Толгойн төслийн усны хоолой, нисэх онгоцны буудал, лицензтэй талбайг тэлэх гэх газрын асуудлуудыг ИТХ-ын шийдвэрийг хүчингүй болгох, дарамталж шийдвэрлүүлсэн, орон нутгийн эрх мэдлийг булаах зэргээр зөвхөн хөрөнгө оруулагчид үйлчилж байна. Хууль бус газар олгуулахыг шаардах, БОНБҮ ний хэлэлцүүлгийг хүчээр зөвшөөрсөн мэт болгох, иргэдийн хэлсэн үг шаардсан хэсгийг бичлэгээс хасч зөвшөөрсөн сайн хүлээж авсан мэтээр худал мэдээлэл цацдаг асуудал түгээмэл байна.
- 2011 оны 8 дугаар сард Баян-Овоо сум орох орон нутгийн зам нийсэх буудлын ьалбай дайрдаг тул хаажээ. Ингэхдээ, иргэдэд мэдээлээгүй, хаагуур тойрж явах тэмдэглэл хийгээгүй байсныг баримтжуулан компанид мэдээлж арга хэмжээ авахыг шаардсан.
- Говь нутгийн ус энэ том уурхайг хангаж хүрэлцэхгүй гэсэн таамаглал ортой гэдгийг компанийн ажиллагсдын хоол ундны усыг савласан усаар хангаж байгаа явдал нотолж байна.

## **II. Шилжүүлэн суурьшилтын асуудлууд**

2004 онд шилжүүлэн суурьшуулсан “Оюу Толгой төслийн өрхүүд” нэртэй 11 өрхийн 7 өрхөөр орж шилжүүлэн суурьшуулснаас хойш амьдрал амьжиргааны байдал, Айвенхоу Майнзтай хийсэн гэрээний биелэлтийн байдалтай танилцсан.

- Шилжүүлэн суурьшуулах тухай гэрээг 1-ээс бусад тохиолдолд урьдчилан танилцуулаагүй, хэлэцээгүй, санал аваагүйгээс гадна өдөр тутам ирж шахаж шаардаж зарим тохиолдолд айлган сүрдүүлсэн, сэтгэл санааны дарамт үзүүлж байгаад зуруулсан байна. Гэрээ байгуулахыг эсэргүүцэж зөвшөөрөхгүй байсан нэг тохиолдолд өрх тэргүүлж буй хүний эзгүйд хөгшин эхээр нь гарын үсэг зуруулсан байна.
- 2004 онд шилжүүлсэн суурьшуудсан иргэдэд зуруулсан гэрээ нь хүчинтэй хугацаа заагаагүй, гомдол гаргах, гэрээний зүйл заалтыг өөрчлөх санал гаргах эрхгүй харин ч шилжүүлэн суурьшуулсан цагаас хойш компанийг аливаа хариуцлагаас чөлөөлнө гэсэн хатуу заалттай гэрээ байгуулагч талуудын ашиг сонирхлын тэнцүү зохицуулах гэрээний наад захын зарчмын баримтлаагүй баримт бичиг болохыг тогтоож компанид мэдэгдэл хийсэн.
- Шилжин суурьших газрын “өөрөө сонгоно” гэж сайн дураар шилжиж байгаа мэт тусгахдаа газар судлах хугацаа өгөөгүй, хүмүүсийн сонгосон газар нь устай, мал маллагаанд тохиромжтой эсэхийг харгалзаагүй буулгаснаас худаг нь усгүй, мал нь бэлчээрт тогтохгүй зэрэг асуудлуудаар хэд хэдэн удаан нүүсэн, хуучин өвөлжөөндөө буусан айлууд байна.
- Шинээр барьж өгсөн байшин, малын хашаа хороо нь бүгд 5-ын банзаар барьсан чанар муутай, гэрээгээр тохирсон хэмжээндээ хүрэхгүй г.м. доголдолтой байна. Жишээлбэл, цахилгаан насос бүхий худаг байгуулж өгсөн гэх боловч нэгээс бусад тохиолдолд цахилгаан насос нь 1 сараас – 1 жилийн дотор эвдэрч ажилгүй болсон байна.

### Шилжүүлсэн зарим өрхүүдийн өвөлжөөнд барьж өгсөн зуны хаус



- Хөлгүй бууцад буух, худаг усгүй болох, мал нь бэлчээр, хулгийн усаа голж хуучин газраа услах, бэлчээрийн даац хэтрэх зэргээр хатуу өвөл малаа алдсан ойл олон байна. Нэг өрх 100 тэмээгээ 20 км газарт хуучин худаг дээрээ усалж олон жил болсон бөгөөд өрхийн тэргүүн нас басрнаас хуучин өвөлжөөндөө буухаас өөр аргагүй болсон зэргээр уулзсан бүх өрхүүдэд сөрөг нийгэм-эдийн засгийнболон сэтгэл санааны хориол нөлөөлөл үзүүлсэн байна.
- Шилжүүлэн суурьшуулах өрх бүрээс нэг хүнийг ОТ-д өндөр цалинтай ажилд авна гэсэн амлалт хамгийн их найдлага турүүлж шилжин суурьшихыг зөвшөөрөхөд нөлөөлсөн хүчин зүйл байна. Гэтэл ажилд авахдаа өрхийн залуу гишүүний авснаар мал маллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байсан хүнийг сонгож, олон хоногоор ОТ-д ажиллаж Ханбогдод амьдрах болсон нь өрхийн амьдрал амьжиргааны олон талын сөрөг нөлөө үзүүлсэн байна. Тухайн өрхийн ажлыг нугалаж байсан хүн холдсоноос амьжиргааа доройтох, гэр бүл салах, хүүхдүүд эцэг эхээс холдох, эрүүл мэндийн байдал доройтох зэрэг олон сөрөг нөлөө бий болсон тухай хүмүүс ярьж байна.
- Нүүлгэн шилжүүлсэн айлуудыг шинэ нутагт бууснаар сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хэрхэн өөрчлөлт орж хуучин байдлаасаа дээрдсэн эсвэл дордсон эсэхийг эргэж үзээгүй, тэдэнтэй эргэх холбоо тогтоогоогүй, эргэж үнэлгээ хийх дэмжлэг үзүүлдэггүй байна.

### III. Шинээр шилжин суурьшуулах эс суурьшуулах тухай асуудлууд

- Зам, нисэх онгоцны буудал, бусад дэд бүтцийн барилгын ажлын нөлөөллийн бүсэд нэлээд олон өрх өртөх бөгөөд эдгээр хүмүүстэй хэлэлцэж байж шийдэх гурван-талт ажлын хэсэг байгуулагдсан сайшаалтай боловч нөлөөллийн бүсэд оршин суугаа хүмүүсийг шилжүүлэхгүйгээр нөхөн олговор олгох, нөлөөллийг сааруулахыг санал болгосон тул иргэд зөвшөөрөхгүй гацаанд орсон, бухимдал нэмсэн асуудал үүссэн байна.

- Нөхөн олговрын гэрээний төслийг компаниас хүсэхэд өгөх боломжгүй гэсэн хариуг удаа дараа өгсөн. 9 дүгээр сарын 23-нд компани, нөлөөллийн бүсийн иргэд ба захиргааны нэгдсэн хурлаар хэлэлцүүлсэн гэрээний төслийг нэг иргэнээс нууцаар аюч үзэхэд гэрээний заалтууд нилээд сайжирсан, ОУСК-ын “шилжүүлсэн бусад хэлбэрээр эдийн засгийн суурьшлаа алдсан өрхүүдийн амьжиргааны түвшинг бууруулахгүй байх зарчмыг эцсийн моментэд оруулж өгсөн байна. Гэхдээ амьжиргааны түвшинг яаж тогтоох, ямар аргачлалаар хэмжих, буурч байгаа эсэхийг хэзээ хэн яаж хянаж байх тухай ганц заалт байхгүй байгаа нь энэ тухай бодитой ажил хийхгүй эгсэн хардлага төруулж байгааг компанид мэдэгдсэн.
- Олон улсын нисэх онгоцны буудлаас 3 км орших айлыг нөлөөллийн бүсэд багтахгүй, компанийн зээлийн хөтөлбөрт хөнгөлөлттэй хамрагд гэж ухуулах зэргээр хуурах, аргадах хэлбэрээр ажиллаад байна гэсэн сэтгэгдэлтэй хүмүүс зөвлөлгөө авахаар холбогдож байна. Нөлөөллийн бүсэд оршин суугч иргэдэд ялгавартай хандах, цөөн буюу ганцаарчилсан байдлаар ярилцах зэргээр иргэдийн дунд хардлага төруулэх, нутгийн иргэдийн эв нэгдлийг эвдэх зэргээр асуудал шийдвэрлэдэг арга хэрэглэж байгаа нь илт бөгөөд үүнийг мөн компанид анхааруулсан болно.
- Айвенхоу\Рио Тинто нөлөөллийн бүсэд оршин суугаа иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, иргэдээр хэлэлцүүлж үйл ажиллагаагаа ойлгуулах, зөвшөөрүүлэх үүргээ гүйцэтгэхгүй хэвээр байна. Нөлөөллийн бүсэд орсон гэх боловч чухам яг ямар нөлөөлөл байх тухай ер ярьж хэлдэггүй, мэдээлэл өгдөггүй гэсэн гомдол гарсаар байна. Өөрсдөө л чимээ, шуугиан, тоосжилт, тав тух алдагдах гэх хэмжээг таахаас биш эрүүл мэндэд, мал маллагаанд, амьжиргаанд яаж нөлөөлөхийг албан ёсны судалгаагаар гаргаагүй, иргэдэд мэдээлээгүй байна.

#### **IV. Ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн цаг\нөхцөл**

- Оюу Толгой төсөлд ажилладаг хүмүүсийн дийлэнх нь 10-12 цаг, дундаа 1 цагийн завсарлагатай ажилладаг бөгөөд нэлээд хэсэг нь, түүний дотор далд (газрын гүнд) болон ил уурхай байгуулж буй хүмүүс ажлын байрандаа халаасан, халаагаагүй хоол идэж амарч байна. Энэ бүлэг ажиллагсдын хувьд ажиллах цаг, хоолны илчлэг болон амрах орчны нөхцөл зэрэг эрүүл мэндэд ноцтойгоор нөлөөлж болох 3 бүлэг эрсдэл тогтоогдож байна.
- 2011 онд мөн л олноор нь хоолны хордлогод оруулсан хэрэг 2 ч удаа гарсан нь ажиллагсдын хоолны илчлэг, зохистой хоолоор хангах үүргээ гүйцэтгэж чадахгүй, наад захын ариун цэвэр хангасан бүтээгдэхүүнд хөрөнгө мөнгө зарцуулахгүй байгаагийн илрэл болно.
- Оюу Толгойн төсөлд ажиллагсдыг согтууруулах ундаагаар үнэгүй хангадаг байснаа зогсоож бар нээн ажиллуулж өдөр бүр “үйлдвэрлэлийн талбай, ажилчид оюутны дотуур байр, орон сууцны хороолол, ажлын байранд согтууруулах ундаа борлуулах, үйлчлэхийг хориглоно” гэсэн Монгол улсын хуулийг зөрчин өдөр бүр согтуулруулах ундаагаар үйлчилж архинд донтох нөхцөлийг бүрдүүлсэн байгааг компанид мэдэгдэхэд “манай компни тусгай зөвшөөрлөө авсан тул хууль зөрчөөгүй болно” гэсэн хариуг албан бичгээр ирүүлсэн нь хуулиас өөр зам байгааг ашигласнаа мэдээлж байгаагийн илрэл.
- 2011 оны 5 дугаар сард 2 хүн, 9 сард 1 хүн мөн 8 дугаард бас 1 хүн амь насаа алдсан мэдээлэл мониторингийн явцад илэрсэн болно. Эдгээр нь ажиллагсдыг аюулгүй ажлын байраар хангах үүргээ компани биелүүлж чадахгүй байгаагийн илрэл юм. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, ажлын аюулгүй ажиллагааны горим

мөрдлөгө болгож чадаагүй, гадаад болон монгол ажиллагсдын харилцааг зохицуулах боломжгүй бол аюулгүй байдлыг хангах, ажилагсдынхаа амь насыг хамгаалах үүргээ биелүүлээгүй ноцтой зөрчил удаа дараа гарч байна. Энэ нь нутгийн иргэдийн оролцооны эрх, мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрхийг үл хүндэтгэн боомилж, үл тоомсорлон зарим манлайлагч иргэдийг “новш хог” хэмээн басамжилэн доромжилсон байдлаар харьцдаг компанийн өөрийн хандлагаас улбаатай гэж нутгийнхан яриж байгаа нь үндэслэлтэй байж болзошгүй. Энэ байдал улмаар туслан гүйцэтгэгч компаниудад нөлөөлж монгол ажилчдыг үл тоох зүй бусаар харьцах, ажлын байран дах бэлгийн дарамт, хүчирхийлэл ч нэлээн байдгийг ажилчид ярьж байна.

- Ажилчдын ҮЭ байгуулагдаагүй, байгуулахаар тэмцсэн нэгийг ажлаас халдаг, дарамталж цалин хөлсийг хасах зэрэг дотоод ардчилгүй, нийгмийн хариуцлагагүй байдал нэлээн байна. Мониторингоор илэрсэн ажлын байртай холбоотой асуудлуудыг нэгтгэн МҮЭХТЗ-д хүргүүлсэн болно.
- Судалгаа, нийцлийн хяналтын үр дүнд үндэслэн олон нийтийн нөлөөллийн ажил, сургалт хийх
- Судалгаа, нийцлийн хяналтын үр дүнд үндэслэн олон нийтийн нөлөөллийн ажил, сургалт хийх

## **Мониторингийн ажлын үр дүн**

2010 он буюу эхний жилийн үр дүнтэй харьцуулахад 2011 онд дараах нааштай эхлэл ба хандлагад хүрсэн гэж дүгнэв. Үүнд:

**Засгийн газрын яам, агентлагийн зүгээс:** 2010 онд тус байгууллагаас хүргүүлсэн албан бичиг, мониторингийн тайлан зэрэг огт хариу өгөхгүй байдлаар эхэлсэн бол мөн оны эцэст “тайлан мэдээ талархан авлаа, хамтран ажиллахад бэлэн” хэмээсэн хариу өгч эхэлсэн. Харамсалтай нь 2011 онд мониторинг хийхэд шаардагдах тодорхой баримт бичгүүд, зөвшөөрлийн бичгүүдийн хувийг авах, ялангуяа Оюутолгой төслийн усны хэрэглээний нь зөвшөөрсөн хэмжээнд байгаа эсэхийг хянах зорилготой холбогдох зөвшөөрлүүдийг хүсэхэд хариу өгдөггүй хэвээр байна.

**Орон нутгийн захиргааны зүгээс:** Мониторингийн ажлаар очиж уулзахад цаг гаргах, компанитай харилцах болон төсөл хэрэгжүүлэх явцад гарч буй асуудлууд дээр мэдээлэл авахад нааштай хандаж аман хэлбээрээр мэдээлэл өгөх, иргэдийн өгч буй мэдээлэлд тайлбар хийх, мэдээлэл солилцох зэргээр харилцаж ирсэн. “Байгаль орчны шинэчлэл -2” төслийн хүрээний сургалт зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, ажиллагсдаа оролцуулах зэргээр хамтарч ажиллаж ирсэн.

Харин мониторингийн хэрэгцээнд баримт мэдээлэл авах хүсэлт удаа дараа албан бичгээр тавьсанд төв засгийн газрын байгууллагууд ба компанийн адил хариу өгдөггүй нь бодит байдлыг баримт материалтай тулгуулахаас зайлхийж байгааг илтгэж байна. Энэ нь мониторингоор илрээд байгаа “зөвшөөрөл авалгүй ажил эхлүүлдэг”, “авсан зөвшөөрлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулаагүй” гэсэн нутгийнхны мэдээлэл ортой болохыг харуулж байгаа юм.

**Компанийн зүгээс:** 2010 оны 4 дүгээр сард үйл ажиллагаагаа албан ёсны бүртгэлтэй явуулж эхэлснээс хойш Айвенхоу Майнз Монголия-гийн ерөнхий захирал Кийт Маршалл өөрийн компанийн байгаль орчин, ус ба нийгмийн асуудал хариуцсан гадаад

болон монгол ажилтнуудаа дагуулж ирж танилцуулснаар мэдээлэл ба нэмэлт тайлбар авах ажиллагаа эхэлсэн юм. Түүнээс хойш 2011 оны дуустал 2 удаа “улирлын уулзалт” хийгдсэн бөгөөд эдгээрийн дундуур Оюу Толгойн төслийн шугамаар ирж буй мэргэжилтнүүд мэдээлэл авах, санал солилцох, судалгааны тайлангаа танилцуулах зэрэг уулзатууд хийгдэх болсон.

Мониторингийн зорилгоор мөн тусгай зөвшөөрөл, баримт мэдээллийн хувийг авах хүсэлт тавьсан тухай бүр боломжгүй гэсэн хариу өгч байсан боловч 2011 оны 11-р сард хийсэн улирлын уулзалтанд “нийцлийн албаны ажилтан” дагуулж ирж ус ашиглахад холбогдох зөвшөөрөл бүхий хавтаст хэрэг байгаагаа харуулсан болно. Хэдийгээр “нийцлийн алба” бий болж хуулийн дагуу зөвшөөрөл, бичиг баримтуудаа цэгцлэж байгаа нь сайшаалтай боловч лиценз, зөвшөөрөл нь тухай газар дээр шалгахад байдаггүй, зөвшөөрлийн хэмжээнд нөөц хэрэглэж байгаа байдлыг нь төлбөрийн баримтуудтай тулгаж нийцлийн хяналт хийх ажиллагааг хязгаарласаар байгаа юм.

Мөн Оюу Толгой төслийн талбайд мониторинг хийхээр нэвтрэх зөвшөөрлийг өөрийн үйл ажиллагааны хүрээнд болон хамтарч ажиллаж буй олон улсын ТББ-ын сүлжээний төлөөлөлд удаа дараа хүссэн боловч зөвшөөрөл олгоогүй болно.

Иймд мониторингийн ажил уурхайн гэрээт талбай, дэд бүтцийн барилгын талбай, төслөөс тавьсан олон замыг тойрсон орчныг ажиглах, тэр орчинд оршин суух иргэдтэй уулзаж мэдээлэл цуглуулах зэргээр байгаль орчны болон нийгмийн нөлөөлөлд ажиглалт хийх ажлаар хязгаарлагдаж байна.

Мониторингийн ажлыг иргэдтэй бүлгээр болон ганцаарчлан уулзах, сургалтын хөтөлбөрийн явцад мэдээлэл цуглуулах, бичгээр асуулга авах зэргээр хэрэгжүүлсэн бөгөөд 2011 онд нийт 5 удаагийн явалтаар мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээлэл дээр дахин хяналтын мэдээлэл авалт хийх зэргээр хэрэгжүүлсэн болно.

➤ Судалгаа, нийцлийн хяналтын үр дүнд үндэслэн олон нийтийн нөлөөллийн ажил, сургалт хийх

Мониторингоор илэрсэн ХО-ын гэрээний болон хуулийн зөрчлийн талаар нийтэд мэдээлэх, хуулийн зүйл заалтууд өөрчлөх санал гаргах, хэлэлцүүлэгт оролцож саналаа хэлэхш УИХ, ЗГ-ын гишүүдэд хандасан мэдээлэл боловсруулж тараах зэргээр ажиллаж ирсэн. Энэхүү үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд 2011 онд ТВ ярилцлага 3, хэвлэлийн ярилцлага 4 үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд, гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хэвлэлийн мэдээ бэлтгэж өгөх зэргээр нийт 6 удаа Монгол дахь олборлох салбарын байдал, түүний дотор Оюу Толгой төслийн нөлөөллийн тухай олон нийтэд мэдээлэх ажил зохион хэрэгжүүлсэн болно. Өнгөрсөн жилийн хугацаанд ХБНГУ-ын олон нийтийн радио, Их Британийн Sunday Mirror, хэд хэдэн чөлөөт сэтгүүлч, олборлох салбарын компаниудын зөрчлийн талаар хэвлэлийн кампанит ажил зохион байгуулж буй сүлжээнд Оюу Толгойн төслийн асуудлаарх мэдээлэл бэлтгэж явуулах зэрэг ажил гүйцэтгэв.

Европын сэргээн босголтын банк (ЕСББ)-ны жил бүр зохион байгуулдаг чуулганы үеэр төрийн бус байгууллагуудын төлөөлөгчидтэй хийдэг уулзалтанд төлөөлөгчөө оролцуулсан. Энэ уулзалт 2011 оны 5-р сард Казахстаны Астана хотод болсон. Энэ уулзалтад тус банкны удирдагч, зөвлөхүүдэд ОТ-н ХО-ын гэрээ, түүнийг хэрэгжүүлэхэд



холбогдох асуудлуудын тухай Монголын иргэний нийгмийн байр суурийг илэрхийлж мэдээлэл өгсөн болно.

Нидерландын вант улсын санхүүжилттэй Дэлхий Банк, БОАЖЯ-ны хамтран хэрэгжүүлж буй төсөлд санал бичиж нийт 21 сая төгрөгийн “Олон улсын стандартын нийцэл – Уугуул иргэдийн хяналт” сэдэвт төслийг 2011 оны 4 сараас хэрэгжүүлж эхлэх гэрээтэйгээр авсан төслийн санхүүжилт нь 6 сарын 6-нд орж ирсэн нь бодитой үйл ажиллагаа явуулж болох 4-6 дугаар сард хийх буюу наадмын өмнө хийхээр төлөвлөсөн ажлыг бүрэн алдагдуулсан болно. Нийт 6 сарын хугацаанд хэрэгжүүлэх төслийн 4 (зуны наадамьн 2 сарыг оролцуулаад) сарыг нь алдсан тул бүрэн хэрэгжүүлэх боломж олгогдоогүй болно. Энэхүү төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан НЕМО-2 төсөл санхүүжилтээ 2 сараар хоцроож 6-р сарын 6-нд шилжүүлсэн бөгөөд 40%-иас илүү олгоогүй буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болно.

Хэдий тийм боловч энэхүү төслийн 40%-ийн санхүүжилтээр 64%-ийн үр дүн гаргаж уул уурхайн салбараас байнга хөндөж байдаг хүний байгаль орчны буюу экологийн эрх, нийгмийн ба эдийн засгийн эрхүүдийг тогтоосон олон улсын стандарт, тэдгээрийн нийцлийг хэрхэн хянах, зөрчлийн талаар гомдол хэрхэн гаргах тухай сургалт Улаанбаатарт ТББ-ын төлөөлөлд 2 удаа хийгдэж нийт: 50 хүн хамарсан. Хөдөө орон нутгийн сургалтыг Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд Дорноговь аймгийн Хатанбулаг, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо, Манлай сумдад тус бүр хоёр хоногийн сургалт нэг удаа явагдаж 140 хүн, байгуулагдсан 4 нийцлийн хяналтын нэгжид хийх сургалт нэг удаа Ханбогд, Манлай сумын НХН-ийг төлөөлөлд хийгдсэн болно. Төслийн хүрээнд олон талт банкуудад гомдол хэрхэн гаргах гарын авлага хэвлүүлж тараах, хэрэгжлэх сургалт хийгдсэн болно.

2011 оны сүүчийн хагаст Оюу Толгойн Хяналт ТББ-ын цахим хуудас ажиллуулах бэлтгэл ажил хийгдэж, эхний ээлжийн мэдээлэл англи хэл дээр тавигдаж туршилтын байдлаар ажилуулж байна.

➤ Хүний эрх, байгаль хамгааллын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын ажиллагааг хөгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ нь үндэдсний байгаль хамгаалах байгууллагуудын МБОИЗ-ийн гишүүн, хөгжлийн өргөн хүрээний асуудлуудаар ажилладаг ИНБ-ын МОНФЕМНЕТ сүлжээний гишүүн бөгөөд 2011 оны 11 сард байгуулагдсан бүсийн Хил хязгааргүй гол мөрөн сүлжээний гишүүн болно. Эдгээр сүлжээнүүдийн хүрэнд хамтарсан үйл ажиллагаа явуулж ирсэн тухай тайлангийн холбогдох хэсгүүдэд багтаасан болно.

➤ Хүний эрх, байгаль хамгааллын олон улсын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын ажиллагааг хөгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ нь ЭЗХХХБ-ын үйл ажиллагааг хянах OECD Watch сүлжээнд 2010 онд Оюу Толгой төслийн тогтвортой байдлын асуудлаар гомдол гаргаж хамтын ажиллагааг эхлүүсэн юм. 2011 онд тус сүлжээнд гишүүнээр элсэн энэ байгууллагын төслийн тэтгэлэгт хөтөлбөрт хандан санал оруулж 2011 оны 11 дүгээр сард 2012 оны 1 улиралд хэрэгжүүлж дуусгах олно улсын гомдлын механизмд гомдолд гаргах төсөл авсан бөгөөд 12 сараас уг төсөл дээр ажиллаж эхэлсэн болно. Уг гомдлыг гаргахад гадаад ба дотоодын хэд хэдэн ТББ-тай хамтран ажиллах хэлбэрээр хамтын ажиллагааг хоёр болон олон талд хэрэгслүүдийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Төв ба Зүүн Европын бүсэд олон улсын банкуудын санхүүжилттэй үйл ажиллагаанд хяналт тавих CEE BankWatch сүлжээний Будапешт, Прага хотод зохиогдсон цианид ба нүүрсээр галладаг ДЦС-ын технологийн сөрөг нөлөөллийн тухай сургалтанд хамрагдаж цаашид хамтран ажиллах талаар тохиролцож ирсэн.

Төв ба Зүүн Европын бүсэд олон улсын банкуудын санхүүжилттэй үйл ажиллагаанд хяналт тавих CEE BankWatch байгууллагын Болгар, Герман, Чех ба Украин дахь зохицуулагчид, АНУ-д дахь Банкны мэдээллийн төв (VIC)-ийн Дэлхийн банкны санхүүжилтэд хяналт тавих мэргэжилтэн нарын 5 хүний бүрэлдэхүүнтэй багийн мэдээлэл цуглуулах, банкуудын хөрөнгө оруулалтад хяналт тавих тухай сургалт, судалгааны ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн. Тус баг Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумдад мэдээлэл цуглуулах ажил хийж Ханбогдод иргэдийн төлөөлөлтэй уулзаж ОУСК, ЕСББ-ны санхүүжилттэй төслийн нөлөөлөлд хяналт тавьдаг, гомдол гаргах тухай сургалт зохион байгуулсан. Мөн сургалтыг үндэсний ТББ-ын төлөөлөлд 6 дугаар сарын 14-ний өдөр Ногоон эвслийн байранд хэрэгжүүлсэн. Төлөөлөгчид уурхайн барилгын талбайд орж мэдээлэл авах, ЗГ-ын яам агентлаг, компани ба ОУСБ-ын удирдлагатай уулзаж мэдээлэл авах хүсэлт тавьсан боловч УИХ-ын нэг гишүүн, ОУСК-ийн төлөөлөгч, Ханбогд сумын Засаг дарга, Энэржи Ресурс-ын Нээлттэй өдөрлөгт оролцож сурталчилгааны мэдээлэл авах зэргээс өөр тал хүлээж авч мэдээлэл өгөхийг эрмэлзээгүй болно.

Ханбогд сумын иргэдтэй мэдээлэл өгөх, санал солилцох уулзалт



Хүний эрх, байгаль хамгаалагчийн эрхийг хамгаалах зорилгынхоо хүрээнд МНГМХ-ний тэргүүн Ц. Мөнбаяр нарын 4 хүнийг баривчилсныг эсэргүүцэж гадаадын хүний эрх, байгаль хамгаалах сүлжээгээр дамжуулан хийж ГХЯ-ны сайдын нэр дээр албан шаардлага хүргүүлэх, үндэсний ТББ-тай хамтран хэвлэлийн мэдэгдэл хийх, мөрдөн байцаалтын ажилд ажиглалт хийж асуулга тавих зэрэг нөлөөллийн ажлын хэлбэрийг ашиглан ажилласан.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR буюу конвенциудын хэрэгжилтийн тайлан авах ажлын хүрээнд “Уул уурхай –Байгаль орчин -Хүний эрх” сэдэвт тайлан бичих ажлын зохион байгуулагчаар ажиллаж ирсэн бөгөөд 2011 оны 3 дугаар сард Женев хотноо болсон Монгол улсын тайланг хэлэлцэн зөвлөлгөө өгөх хуралд мэдэгдэл хийсэн. Мэдэгдэлд МУ-ын Засгийн газар Аархусын конвенцид нэгдэх, иргэдийнхээ эрүүл

авулгүй орчинд амьдрах, бэлчээр эзэмших зэрэг уламжлалт эрхийг хамгаалах тухай зөвлөмжүүдийг хүлээж аваагүйг анхааруулсан болно.

Олборлох салбарын ил тод байдлын санаачлага (ЕІТІ) хөтөлбөрийн Азербайжан дахь Евроазийн сургалтын төвийн 2011 оны 2 дугаар сард явагдсан сургалтаас сонгогдож 2011 оны 12 сарын 3-5-ны өдрүүдэд Баку хотод болсон сургагч багшийн сургалтанд сууж энэ санаачлагын хүрээнд хийгдэх сургалтын хөтөлбөрүүдэд багшаар оролцох эрхийн гэрчилгээ авч хамтын ажиллагааны эхлэл тавьсан болно. Оюу Толгойн Хяналт ТББ-ын мониторингийн ажлыг Олборлох салбарын ил тод байдлын санаачлагын хүрээнд явагдах үйл ажиллагаатай хослуулан явууллах цаашдын ажлын боломж үүгээр нээгдэж байгаа юм.

2011 онд байгуулагдсан Хил Хязгааргүй Гол Мөрөн бүсийн байгууллагын гишүүн болсон бөгөөд энэ чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлж 2011 оны 12 дугаар сарын 15-16-нд Женев хотод хуралдсан НҮБ-ын “Хил дамнасан гол мөрний асуудлаарх олон улсын бага хурал”-д оролцож Орхон-Говь, Хэрлэн-Говь төслүүдийн талаар мэдээлэл хийсэн бөгөөд мөн байгаль орчны хил амнасан нөлөөллийн талаарх ажлын эхлэл тавигдсан болно.

➤ Орон нутгийн иргэний нийгэмтэй харилцаа хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах

Нидерландын вант улсын санхүүжиттэй энэхүү сургалт нь орон нутагт байгаль орчин, хүний олон улсын стандартын тухай мэдлэгийг түгээх, хяналтыг зохион байгуулах, зөрчлийн талаар гомдол гарагх чадавх бий болгоход дэмжлэг үзүүлэх замаар орон нутагт ИНБ-дын үйл ажиллагааг дэмжих зорилготой төсөл байсан болно.

Нидерландын вант улсын санхүүжилттэй Дэлхий Банк, БОАЖЯ-ны хамтран хэрэгжүүлж буй төсөлд санал бичиж нийт 21 сая төгрөгийн “Олон улсын стандартын нийцэл – Уугуул иргэдийн хяналт” сэдэвт төслийг 2011 оны 4 сараас хэрэгжүүлж эхлэх гэрээтэй авсан төслийн санхүүжилт нь 6 сарын 6-нд орж ирсэн нь наадамьн өмнө хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бүх ажлыг алдагдуулснаар төслийн эцсийн үр дүнд шууд сөргөөр нөлөөлсөн болно. Нийт 6 сарын хугацаанд хэрэгжүүлэх төслийн 4 сар (зуны наадамьн 7-8 сар оруулаад)-ыг нь алдсан тул бүрэн хэрэгжүүлэх боломж олгогдоогүй болно. Мөн санхүүжилтээ ч энэ төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан НЕМО-2 төсөл 2 сар хоцроож шилжүүлсэн бөгөөд зөвхөн 40%-ийг олгосон буюу гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй болно.

Хэдий тийм боловч дээрх 40%-ийн санхүүжилтээр төслийн үр дүнгийн 64%-д хүргэж уул уурхайн салбараас байнга хөндөж байдаг хүний байгаль орчны буюу экологийн эрх, нийгмийн, эдийн засгийн эрхүүдийг тогтоосон олон улсын стандартын тухай, тэдгээрийн нийцлийг хэрхэн хянах, зөрчлийн талаар гомдол хэрхэн гаргах тухай сургалт Улаанбаатарт ТББ-ын төлөөлөлд 2 удаа хийгдэж нийт: 50 хүн хамрасан. Хөдөө орон нутгийн сургалтыг Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд Дорноговь аймгийн Хатанбулаг, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо, Манлай сумдад тус бүр хоёр хоногийн сургалт нэг удаа явагдаж 140 хүн, байгуулагдсан 4 нийцлийн хяналтын нэгжийн сургалт нэг удаа Ханбогд, Манлай сумын НХН-ийг төлөөлөлд хийгдсэн болно.

➤ Хөрөнгө босгох төсөл боловсруулах, хэрэгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ-ын өөрийн үйл ажиллагаа явуулах зорилго бүхий хөрөнгө босгож чадаагүй. Харин нийт 5 төслийн санал боловсруулж донор байгууллагуудад хандаж үүнээс 3 төслийн санхүүжилт авч хэрэгжүүлсэн болно . Үүнд:

Green Grants Fund – ОУСК, ЕСББ зэрэг санхүүгийн байгууллагуудын иргэний мониторинг ба гомдлын механизмын үйл ажиллагааны тухай сургалт зохион байгуулахад – хэрэгжүүлж 2011 эхий улиралд хэрэгжүүлж дууссан.

БО Шинэчлэл (НМО) 2 төслийн хүрээнд “Олон улсын стандартын нийцэл – Уугуул иргэдийн хяналт” сургалтын төсөл хэрэгжүүлэхээр авсан боловч санхүүжүүлэгч байгууллага санхүүжилтээ хугацаанд нь болон бүрэн олгоогүй хаасан.

OECD Watch – байгууллагын гомдол гарах 2011 оны 11 сард авсан одоо хэрэгжих буй төсөл эдгээр болно.

ТА ЯАЖ ОРОЛЦОЖ БОЛОХ ВЭ?

- Оюу Толгойн Хяналт ТББ-д холбогдож хүний эрх ба байгаль хамгааллын олон улсын эрх зүйн баримт бичгүүд, стандартын талаар мэдээлэл, сургалт, зөвлөлгөө авах
- Уул уурхайн орчимд амьдрах иргэд нийцлийн хяналтыг газар дээр нь хийх, баримтжуулах чадавх эзэмшүүлэх сургалт хамтран зохион байгуулах, хяналтын бүлэг байгуулж ажиллуулах
- Иргэдийн хяналтын сүлжээ хөгжүүлэх чиглэлээр сургалт явуулдаг ТББ-ууд олон улсын хүний эрх, байгаль хамгааллын эрх зүй, нийцлийн хяналт, гомдлын механизмуудыг ашиглахад суралцах хамтарсан сургалт зохион байгуулах
- Аль ч аймаг сумын иргэд, ТББ-ууд манай сургалтанд оролцож нийцлийн хяналтын тогтолцоог өөрийн нутагт байгуулах дэмжлэг авах
- Хүний эрх, байгаль орчны зөрчлийн асуудлаар гомдол гаргах хэргийн баримт бүрдүүлэх талаар зөвлөлгөө авах
- Өөрийн нутагт хэрэгжүүлж буй нийцлийн хяналтын ажлын талаарх мэдээллийг манай байгууллагаар дамжуулан үндэсний болон гадаадын ТББ-ын сүлжээнд холбогдох, мэргэжлийн мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр хамтран ажиллаж болно

**ОЮУ ТОЛГОЙН ХЯНАЛТ ТББ**

Хаяг: СБД, Бага Тойруу, 44-6

Имэйл: [otwatch@gmail.com](mailto:otwatch@gmail.com)

Факс: 976-11-328798

Гар: 976-98905828

